Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчиний яамны зүгээс 100 МВт-ын хүчин чадалтай Усан цэнэгт цахилгаан станц барьж байгуулах боломжтой газруудын талаарх урьдчилсан судалгааны ажлыг хийж Хэрлэн голд 3, Ерөө голд 1, Орхон голд 1 байршлыг тус тус илрүүлж, урьдчилсан тооцоо, судалгааны дунд Дэлхийн банктай хамтран Хэрлэн голд Усан цэнэгт цахилгаан станц барих байрлалыг олох, ТЭЗҮ хийх төсөл хэрэгжүүлэхээр тохиролцож судалгааны ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.</li> <li>Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг, Хэрлэн голын эрэгт барихаар төлөвлөж буй 45 МВт-ын хүчин чадалтай ус хуримтлуурт цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэгч "Эрдэнэс пауэр" ХХК-д эрчим хүчиний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг олгох тухай зөвлөмжийг ЭХЗХ-нд өгсөн.</li> <li>Орхон аймгийн Баян-Өндөр суманд барихаар төлөвлөж буй "Эрдэнэт усан цэнэгт цахилгаан станц" ХХК-ийн 50МВт-ын хүчин чадалтай станцын төслийг хэрэгжүүлэхэд дэмжиж ажилласан.</li> <li>"Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц" ХХК-ийн барихаар төлөвлөж буй 100МВт-ын хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэлийг насос-турбин хосолсон үр ашигтай тоног, төхөөрөмжөөр техник эдийн засгийн үндэслэлийг баяжуулж, шинэчлэх шаардлага тавин ажилласан.</li> </ul> <p>Сан хидро ХХК Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт Майхан ууланд 75 МВт-ын хүчин чадалтай Усан цэнэгт цахилгаан станц барьж байгуулах ТЭЗҮ-ийг Эрчим хүчиний яамны ШУТЗ-ын 2020 оны 06 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Сан хидро ХХК-д эрчим хүчиний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгох асуудлыг судлах шийдвэрлэх асуудлыг ЭХЗХ-нд, УЦС-ын газрын асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг НЭДТГ-т тус тус уламжилсан.</p>					
	Зарцуулсан хөрөнгө	-					
	Хүрсэн түвшин	100%					
	Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%					

Гүйцэтгэлийн зорилт № 1.6. Хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хуртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх.

Төлөвлөлтийн уялдаа: Төрөөс эрчим хүчиний талаар баримтлах бодлогын зорилт 3.2.1.4.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
Арга хэмжээний нэр, дугаар	1.6.1. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгүүдийн төв болон томоохон суурин газруудад дулааны станц, дулааны шугам сүлжээ барих, тулшиний хангамжийг шийдвэрлэх.

**Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө**

	<b>Төлөвлөлтийн уялдаа:</b>	ЗГУАМХ – 2.102, МУНЭЗХҮЧ-6.6, ТЭХТБББ- 3.2.1.4, ТЭХТБХДХҮХ 3.4.1.				
<b>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	<b>Хэрэгжих хугацаа</b>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<b>Шаардагдах хөрөнгө</b>	БНСУ-ын урт хугацаатай хөнгөлөлттэй зээл, 145 сая ам.доллар				
	<b>Хариуцах нэгж</b>	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Эрчим хүч, тулшний бодлогын хэрэгжилтийн газар, Д.Батзориг				
	<b>Суурь түвшин</b>	Төслийн зөвлөх компанийтай гэрээ байгуулсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна.				
	<b>Шалгуур үзүүлэлт</b>	Гүйцэтгэгчийг шалгаруулах, Барилга угсралтын ажлын явц, %				
	<b>Хүрэх түвшин</b>	<b>Эхний хагас жилд:</b> Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна, 100% <b>Жилийн эцэст:</b> Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна, 10%				
<b>Арга хэмжээний хэрэгжилт</b>	<b>Хэрэгжилт</b>	Төслийн Зээлийн гэрээнд заасны дагуу барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг БНСУ-ын компаниудын дунд 2020.02.13-ны өдөр 60 хоногийн хугацаатай зарласан боловч хорио цээрийн дэглэмийн улмаас тендер нээх хугацаа 2020.05.06-ны өдрийг хүртэл сунгагдсан. Монгол Улсад тендерийг хүлээн авах боломжгүй байсан тул БНСУ-ын “Экспорт-Импорт” банк дээр компаниудын тендерийн материалыг 2020.05.06-ны өдөр хүлээн авч, Үнэлгээний хороонд цахим хувилбарыг ирүүлэхээр зохион байгуулсан боловч дурьдсан хугацаанд нэг ч компани тендерийн материал ирүүлээгүй. Тендер амжилтгүй болсон шалтгааныг судлан үзэхэд Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа хэт богино, улс орнуудад тогтоосон хөл хорооны улмаас төсөл хэрэгжүүлэх талбайтай танилцах боломж байгаагүй, төслийн технологи сонгох, үнийн санал гаргах боломжгүй; тоног төхөөрөмж худалдан авах компаниудтай гэрээ хэлцэл хийх боломжгүй; хөл хорооны дэглэм цаашид хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй тул барилга угсралтын ажлыг хэзээ эхлүүлэх нь тодорхойгүй гэж үзсэн байсан. Тендерийг дахин 2020.05.27-ны өдөр 30 хоногийн хугацаагаар зарласан. Төслийн 2 дахь удаагийн тендерт материал ирүүлсэн хоёр компанийн техникийн саналыг 2020.06.26-ны өдөр, техникийн шаардлагыг хангасан нэг компанийн санхүүгийн саналыг 2020.08.26-ны өдөр нээсэн. Тендерт санал ирүүлсэн нэг компанийн техникийн санал шаардлага хангаагүй, негээ компанийн үнийн санал хэт өндөр байсан тул аль алиных нь саналаас татталзаж байгаагаа 2020.10.02-ны өдөр компаниудад мэдэгдсэн. БНСУ-ын “Экспорт-Импорт” банк 2020.10.30-ны өдөр дахин тендер зарлах зөвшөөрөл ирүүлсний дагуу 2020.11.24-ний өдөр ЭХЯ-ны ТНБД-ын тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо ажиллаж байна. Үнэлгээний хороо, төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани хамтран өмнөх тендерүүд амжилтгүй болсон шалтгаан, дахин зарлах тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг оруулан боловсруулж байна.				
	<b>Зарцуулсан хөрөнгө</b>	-				
	<b>Хүрсэн түвшин</b>	50%				
	<b>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</b>	50%				

<b>№</b>							<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>
<b>Арга хэмжээний нэр, дугаар</b>	1.6.2. Улаанбаатар хотын гэр хорооллын барилгажилттай уялдуулан алслагдсан дүүргүүдэд хэсэгчилсэн дулаан хангамжийн систем байгуулах төслийг үе шаттайгаар эхлүүлэх.						
	<b>Төлөвлөлтийн уялдаа:</b>	ЗГУАХ – 2.102, МУНЭЗХҮЧ-6.6, ТЭХТБББ- 3.2.1.4, ТЭХТБХДХҮХ 3.4.2.					
<b>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	<b>Хэрэгжих хугацаа</b>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
	<b>Шаардагдах хөрөнгө</b>	АХБ-ны зээл, Батлагдсан төсвийн хүрээнд					
	<b>Хариуцах нэгж</b>	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий					
	<b>Суурь түвшин</b>	Судалгааны ажлууд хийгдсэн					
	<b>Шалгуур үзүүлэлт</b>	Хэсэгчилсэн дулаан хангамжийн систем үе шаттай хэрэгжих явц, %					
	<b>Хүрэх түвшин</b>	<b>Эхний хагас жилд:</b> Дамбадаржаа, Толгойт, Шар хад дэд төвүүдийн техникийн шийдлийг гаргасан байна, 100% <b>Жилийн эцэст:</b> судалгааны ажлуудыг бодлогын удирдамжаар хангасан байна, 100%					

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Зорилт арга хэмжээг Улаанбаатар хотын гэр хорооллын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслөөр дамжих хэрэгжүүлж байна. УБ хотын төвлөрлийг сааруулах зорилгоор б дэд төвийг хөгжүүлэн гэр хорооллыг барилгажуулах хөгжүүлэх юм. б дэд төвийн дулаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд Төслийн Удирдах хороо, тесэл хэрэгжүүлэх нэгжээр дамжуулан бодлогын удирдамжаар ханган ажиллаж байна. Дамбадаржаа дэд төвийг бие даасан эх үүсвэртэй байхаар ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг олгосон бөгөөд ТЭЗҮ ЭХЯ-ны ШУТЗ-ийн 05 дугаар сарын хурлаар хэлэлцэгдэн дэмжигдсэн.</p> <p>Дарь-Эх дэд төвийн дулаан хангамжийг шийдвэрлэх ажлын хэсгийг Нийслэлийн ЗДТГ-аас томилон ажиллуулж, оргил ачааллын эх үүсвэртэй төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон байх шийдвэрлэд хүрснийг үндэслэн ТЭЗҮ ажлын даалгаврыг боловсруулан хүргүүлсэн. .</p> <p>Толгойт дэд төвийг УБДС-нд хэрэгжиж буй ЕСБХБ-ны зээлээр шинээр баригдах дулаан дамжуулах шугамыг түшиглэн төвлөрсөн дулаан хангамжид холбох, Шар хад дэд төвийг Амгалан ДС-ын өргөтгөлтэй холбоотойгоор дулаан дамжуулах шугамыг барьж байгуулан төвлөрсөн дулаан хангамжид холбох байдлаар дулаан хангамжийг нь шийдвэрлэхээр эхний саналыг хэлэлцэж байна. Шийдвэр албажин гараагүй Төслийн гуравдугаар үе шатанд хэрэгжих төлөвлөгөөтэй байна..</p>
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгuur үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.6.3. Хот, суурин газрын дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийх. Төлөвлөлтийн 3ГУАХ – 2.102, МУНЭЗХҮЧ-6.6, ТЭХТБББ- 3.2.1.4, ТЭХТБХДХҮХ уялдаа:						
Гүйцэтгэлийн шалгур үзүүлэлт	Хэрэгжихи хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
	Шаардагдах хөрөнгө	Улсын төсөв, Батлагдсан төсвийн хүрээнд					
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Эрчим хүч, тулшний бодлогын хэрэгжилтийн газар, Д.Батзориг					
	Суурь түвшин	Батлагдсан төсвийн хүрээнд дулаан хангамжийн системийг үе шаттайгаар шинэчилж байна.					
	Шалгур үзүүлэлт	Батлагдсан төсвийн хүрээнд өргөтгөл шинэчлэлтийн явц, %					
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж БУА эхэлсэн байна, 50% Жилийн эцст: барилга угсралтын ажил дууссан байна, 100%					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, зарим аймгийн төвийн дулаан хангамжийн системийг шинэчлэх төслийг БНСУ-ын Экспорт-импортын банктай хамтран ажиллаж байна.</p> <p>Эдгээр төслийд гадна Улаанбаатар хотод, халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хүрээнд дулааны 7И магистралийн 3,7 км Ф700 мм голчтой шугамыг барих ажлыг 2020 оноос 16,4 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд 58 хувийн гүйцэтгэлтэй, он дамжин хэрэгжинэ. Мөн Дулааны 4-р цахилгаан станцаас Яармагийн гэр хороолол дундуур шинэ төлөвлөлтийн бус рүү Ф600 мм голчтой 1,2 хос.км 3,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий дулааны магистраль шугам шинээр татаж ашиглалтад оруулсан.</p> <p>Төвлөрсөн дулаан хангамжтай Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг хотуудын дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил улсын төсөв, нийслэлийн төсөв, компанийн хөрөнгө оруулалтуудаар төвлөгөөний дагуу хэрэгжих байна.</p> <p>БХБЯ-ны сайдын багцаас Дархан-Уул аймгийн төв Дархан сумын 5,6,7,8 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн хангамжтай болгох төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Төслийн хүрээнд 16 ус, дулаан дамжуулах төв, 1 насос станц, халаалт халуун усны нийт 11,2 хос км шугамын ажил хийгдэх ба ажлын гүйцэтгэл 80 хувьтай, он дамжин хэрэгжинэ.</p> <p>Дорноговь аймгийн дулааны станцын зуух шугам сүлжээний шинэчлэлтийн хүрээнд 4 дулаан дамжуулах төвийн барилга,</p>					

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

		тоноглолтын хамт 971 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, Зуухны шинэчлэлт 2,3 тэрбум төрөгийн төсөвт өртөг бүхий ажлууд Улсын төсвөөр хийгдэж 2020 онд ашиглалтанд орсон. Хэнтий аймгийн Бэрх тосгонд Дулааны станц шинээр барих, дулаан дамжуулах төв, шугам сүлжээ барих ажлуудын ТЭЗҮ боловсруулагдан 2021 онд эхлэнэ. Хэнтий аймгийн төв Хэрлэн суманд дулаан түгээх шугам сүлжээний шинэчлэлтийн ажил 2020 оноос эхэлсэн, 2021 онд үргэлжлэн хийгдэнэ.
Зарцуулсан хөрөнгө	-	
Хурсэн түвшин	100%	
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%	

Гүйцэтгэлийн зорилт № 1.7. Бус нутгийн эрчим хүчиний системийг дамжуулах чадал өндөр цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчиний нэгдсэн систем байгуулах.

Төлөвлөлтийн уялдаа: Төрөөс эрчим хүчиний талаар баримтлах бодлогын зорилт 3.2.1.5.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгур үзүүлэлт, хүрэх түвшин										
Арга хэмжээний нэр, дугаар	1.7.1. Чойр-Сайншандын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлыг эхлүүлэх.										
	Төлөвлөлтийн уялдаа:										
Гүйцэтгэлийн шалгур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал					
	Шаардагдах хөрөнгө	ЗГҮАХ – 2.105, ТЭХТББ 3.2.1.5, 3.5. ЭЗНХҮЧ-ийн 6.5 -р арга хэмжээ									
	Хариуцах нэгж	ЕСБХ-ийн банкны зээл, тусlamж, 63.5 сая ам.доллар									
	Суурь түвшин	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий									
	Шалгур үзүүлэлт	Европын сэргээн босголт хөгжлийн банкны урт хугацаатай хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр 2019 онд Засгийн газрын шийдвэр гарсан.									
	Хүрэх түвшин	ТЭЗҮ, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний явц, %									
Арга хэмжээний хэрэгжилт	Эхний хагас жилд: ТЭЗҮ шинэчилсэн, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийсэн байна, 50%										
	Жилийн эцэст: ТЭЗҮ болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна, 100%										
	Хэрэгжилт	Сангийн яам болон Европын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд уг төслийг санхүүжүүлэх боломжийг судлан дэмжиж өгөхийг хүссэн Эрчим хүчиний сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн a/2357 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.									
		Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-т хоёр тал 2019 оны 04 дүгээр сард гарын үсаг зурсан бөгөөд энэхүү хэлэлцээрийн 300 сая ам.долларын санхүүгийн эх үүсвэрээс Чойр-Сайншандын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг санхүүжүүлэх асуудлыг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Европын сэргээн босголт хөгжлийн банктай төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна. Тус банкнаас зөвлөхийг сонгон шалгаруулсны дагуу Чойр-Сайншандын 220 кВ-ын ЦДАШ, 220 кВ-ын дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн судалгаа хийгдсэн. Мөн Техникийн туслалцааны хүрээнд төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэж дууссан бөгөөд олон нийтийн санал асуулга явуулахаар ажиллаж байна.									
	Зарцуулсан хөрөнгө	-									
	Хурсэн түвшин	100%									
	Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%									

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.7.2. Багануур дэд станцыг Улаанбаатар дэд станцтай холбох 220 кВ-ын 2 хэлхээт 118 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, дэд станцуудыг өргөтгөх ажлыг эхлүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа:					
Гүйцэтгэлийн шалгур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	ЗГҮАХ – 2.105, ТЭХТББ 3.2.1.5, 3.5. ЭЗНХҮЧ-ийн 6.5 -р арга хэмжээ				
		Гадаадын зээл, тусlamж, 85.0 тэрбум төгрөг				

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий
	Суурь түвшин	Бодлогын баримт бичигт туссан.
	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилтийн явц, %
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Санхүүжилтийн асуудлаар холбогдох газарт хандсан байна, 10% Жилийн эцэст: Санхүүжилтийн асуудлаар холбогдох газарт хандсан байна, 10%
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкинд санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар хүсэлт тавьсан боловч Засгийн газрын зүгээс баталгаа гаргуулах мэдээлэл ирүүлсэн. Засгийн газар аливаа төслийн санхүүжилтэд баталгаа гаргахгүй байгаа болно. Дэлхийн банкинд тусгуулах саналыг 2021.01.22-ны өдрийн a/276 албан бичгээр Сангийн яаманд <b>хүргүүлсэн</b> .
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.7.3. Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих.					
	Төлөвлөлтийн уялдаа:					
	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	ЗГУАХ – 2.105, ТЭХТБББ 3.2.1.5, ТЭХТБХДХҮХ 3.5.5. ЭЗНХҮЧ-ийн 6.5 -р арга хэмжээ				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Эрчим хүч, тулшиний бодлогын хэрэгжилтийн газар, Д.Батзориг				
	Суурь түвшин	ТЭЗҮ, зураг төсөв бэлэн болсон.				
	Шалгуур үзүүлэлт	БУА-ын ажлын явц, %				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: БУА-ын гэрээ байгуулсан байна, 100% Жилийн эцэст: БУА 30%-д хүрсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 388 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалт"-д Эрчим хүчиний сайдын багцаас Тайширын УЦС-аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээ тусгагдсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч тендерт оролцогдоос маргаан үүсч шүүхэд шилжсэн ба шүүхийн маргаан оны 4 дүгээр улиралд эцэслэгдсэнээр Худалдан авах ажиллагааны газраас дахин нээлттэй тендерийг 2020.12.12-нд зарлаж 2021.01.11-ний өдөр "ДМТМ" ХХК болон "Биндэгноров" ХХК-ийн түншлэл шалгарсан.				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	50%				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		50%				

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.7.4. Багануур-Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 518 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, 220 кВ-ын дэд станцыг өргөтгөх ажлыг эхлүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа:					
	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	ЗГУАХ – 2.105, ТЭХТБББ 3.2.1.5, ТЭХТБХДХҮХ 3.5.6. ЭЗНХҮЧ-ийн 6.5 -р арга хэмжээ				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж	Гадаадын зээл, тусламж, 302,895.0 сая төгрөг				
	Суурь түвшин	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий ТЭЗҮ боловсруулагдсан.				
	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилтийг шийдвэрлэх явц, %				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Санхүүжилтийн асуудлаар холбогдох газарт хандсан байна, 10%				

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

		<b>Жилийн эцэст:</b> Санхүүжилтийн асуудлаар холбогдох газарт хандсан байна, 30%
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Багануур-Өндөрхаан чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт 202.4 км ЦДАШ, дэд станц барих ТЭЗҮ-ийг боловсруулан салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн.</p> <p>Төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын "Эдийн засгийн коридор"-ын төсөл, хөтөлбөрийн жагсаалтад оруулсан. Мөн Концессын зүйлийн жагсаалтад тусгахаар саналаа Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.</p> <p>Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Сангийн яам хооронд байгуулсан 300 сая ам.долларын зээлийн еренхий хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх боломжийг судлан дэмжиж өгөх тухай албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. Санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдсэнд дараа энэ төслийн ажил эхлэх тул хэрэгжих хугацаа тодорхойгүй байна.</p> <p>Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх боломж бүрдэхгүй байгаа. Монгол улсын эрчим хүчиний нэгдсэн систем үүсгэх чухал ач холбогдолтой төсөл тул 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдсан Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050"-д 2024 он гэхэд ашиглалтанд орсон байхаар тусган батлуулж, ЗГ-ын 2020.12.09-ний өдрийн хуралдаанаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021 оноос эхлүүлэхээр тодотгон тусгасан.</p>
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн тувшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх тувшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.7.5. Багануур дэд станцаас Чойр хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 178 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Багануур дэд станцыг өргөтгөх.						
	Төлөвлөлтийн уялдаа:	ЗГУАХ – 2.105, ТЭХТБББ 3.2.1.5, ТЭХТББХДХҮХ 3.5.7. ЭЗНХҮЧ-ийн 6.5 -р арга хэмжээ					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
	Шаардагдах хөрөнгө	Гадаадын зээл, тусламж, 110.000.0 сая төгрөг					
	Хариуцах нэгж Суурь тувшин	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий					
	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилтийг шийдвэрлэх явц, %					
	Хүрэх тувшин	<p>Эхний хагас жилд: Санхүүжилтийн асуудлаар холбогдох газарт хандсан байна, 10%</p> <p><b>Жилийн эцэст:</b> Санхүүжилтийн асуудлаар холбогдох газарт хандсан байна, 30%</p>					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Монгол улсын эрчим хүчиний нэгдсэн систем үүсгэх чухал ач холбогдолтой здгээр төслүүд 2020.05.13-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдсан Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050"-д 2024 он гэхэд ашиглалтанд орсон байхаар тусган батлуулж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021- оноос эхлүүлэхээр тодотгон тусгасан. "220 кВ-ын Багануур дэд станцаас Чойр хүртэл 220 кВ-ын хоёр хэлхээт 178 км ЦДАШ барих, дэд станц өргөтгөх", "Багануур-Өндөрхаан чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт 202.4 км ЦДАШ, дэд станц барих ТЭЗҮ-дийг боловсруулан салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн байдал ба, тодотгох шаардлагатай.</p> <p>Дээрх хоёр төслийн хөрөнгө оруулалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Сангийн яам хооронд байгуулсан 300 сая ам.долларын зээлийн еренхий хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх боломжийг судлан дэмжиж өгөх тухай албан тоотыг 2020 онд Сангийн яаманд хүргүүлсэн.</p>					
	Зарцуулсан хөрөнгө	-					
	Хүрсэн тувшин	100%					
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%					

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.7.6. Эрдэнэбүрэн-Улиастайн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын судалгааг хийх, ажлыг эхлүүлэх;					
Төлөвлөлтийн уялдаа:	ЗГУАХ – 2.105, ТЭХТБББ 3.2.1.5, ТЭХТБХДХҮХ 3.5.8.					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Гадаадын зээл, тусламж, 280,000.0 сая төгрөг				
	Хариуцах нэгж Суурь түвшин	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий				
	Шалгуур үзүүлэлт	-				
	Хүрэх түвшин	Урьдчилсан судалгааны ажлын явц, %				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Эхний хагас жилд: Урьдчилсан судалгааны дууссан байна, 100% Жилийн эцэст: Урьдчилсан судалгааны ажлыг ШУТЗ-вөр хэлэлцүүлсэн байна, 100%				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хурсан түвшин	30%				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	30%					

Гүйцэтгэлийн зорилт № 1.8. Хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох урт хугацааны харилцан ашигтай гэрээ байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Төлөвлөлтийн уялдаа: Төрөөс эрчим хүчиний талаар баримтлах бодлогын зорилт 3.2.2.1.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.8.1. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын эрчим хүчиний хамтын ажиллагааны гэрээ байгуулах.					
Төлөвлөлтийн уялдаа:	ТЭХТБББ 3.2.2, ТЭХТБХДХҮХ 3.7.2					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий				
	Суурь түвшин	Төрийн захирагааны удирдлагын газар, Р.Батрагчаа				
	Шалгуур үзүүлэлт	ЗГ хоорондын хэлэлцээрийн тесел бэлэн болсон.				
	Хүрэх түвшин	ЗГ хооронд гэрээ байгуулах ажлын явц, %				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Эхний хагас жилд: Гэрээ хэлэлцээрийт ЗГ-ын хурлаар хэлэлцүүлсэн байна, 100% Жилийн эцэст: Гэрээ хэлэлцээр байгуулах чиглэлээр тодорхой ажлууд хийгдсэн байх, 100%				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хурсан түвшин	100%				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%					

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.8.2. Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн уурхайн өргөтгэл, 5280 МВт-ын чадал бүхий цахилгаан станц, 660 кВ-ын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барьж эрчим хүч экспортлох гэрээ байгуулах, төслийг эхлүүлэх.					
Төлөвлөлтийн уялдаа:	ТЭХТБББ 3.2.2.1, ТЭХТБХДХҮХ 3.7.4					

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
	Шаардагдах хөрөнгө	-					
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий					
	Суурь түвшин	Техникийн ТЭЗҮ бэлэн болсон.					
	Шалгуур үзүүлэлт	ТЭЗҮ-ийг салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлэх явц, %					
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Эдийн засгийн хувилбарт тооцоог хүлээн авсан байна, 100%					
		Жилийн эцэст: Эдийн засгийн хувилбарт тооцоог хүлээн авч, Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна, 100%					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Шивээ-Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэсэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай, станцын усан хангамжийн "Шивээ-Энержи" цогцолбор төслийн ТЭЗҮ-г БНХАУ-ын ЦДУС компани боловсруулж, State Gread-ийн дотоод хяналтаар хянаагдаж, 2017.12.20-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан хоёр талын хамтарсан ажлын хэсгийн анхдугаар хурлаар ТЭЗҮ-ийг хүлээн авсан. Эрчим хүчиний сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай, усан хангамжийн талаар өөр өөр институтуудын боловсруулсан ТЭЗҮ-үүдийг судлан үзээд ТЭЗҮ тус бүрт шүүмж өгсөн. Монгол-Хятадын Ажлын хэсгийн хамтарсан хуралдаанд ус, нүүрс, цахилгаан станц гэсэн 3 ажлын Дэд хэсгүүдэд хуваагдаж төслийн техникийн мэдээллийг нарийвчлан ярилцаж Монголын талын ажлын хэсгийн дүгнэлтүүдийг тэмдэглэлд тусгуулсан. Хоёр тал энэхүү хамтран хэлэлцэсн асуудлуудаар протокол үйлдсэн бөгөөд Монголын талаас Хятадын талд уг төслийн технологийн үзүүлэлт нь Евро стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай талаар саналаа албан ёсоор илэрхийлсэн. ТЭЗҮ-ийн эдийн засгийн үр ашгийн хувилбарт тооцоо ирүүлээгүй, хүлээгдэж байна. Хашаат цавын уурхай дээр 3000 МВт-ын экспортын зориулалттай цахилгаан станц барих тусгай зөвшөөрөл авсан "Би Эс Юу" ХХК-д төслийн ажлын хүрээнд дэмжлэг үзүүлэн ажилласан. Тус компани нь төслийн ажлыг 3 үе шаттайгаар нийтдээ 10 жилийн хугацаанд барьж байгуулахаар төлөвлөж байгаагаа мэдэгдсэн. Эрчим хүчиний яамнаас БНХАУ-ын холбогдох эрх бүхий байгууллагатай цахилгаан эрчим хүч нийлүүлэх, Монголоос экспортлох талаар гэрээгээ байгуулж, хариу мэдэгдэх чиглэлийг өгч ажилласан.					
	Зарцуулсан хөрөнгө	-					
	Хүрсэн түвшин	70%					
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		70%					

Гүйцэтгэлийн зорилт 1.9. Олон улсын байгууллага, бус нутгийн орнуудын эрчим хүчин хамтын ажиллагааны санал санаачилгад идэвхтэй оролцох, хамтран ажиллах.

**Төлөвлөлтийн уялдаа: Төрөөс эрчим хүчин талаар баримтлах бодлогын зорилт 3.2.2.2.**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.9.1. Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Их түмэн санаачилга, Эрчим хүчиний Харти, Нэг зам нэг бус, Зүүн хойд Азийн эрчим хүчиний нэгдсэн сүлжээ байгуулах зэрэг олон улсын санаачилга, бус нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох.					
	Төлөвлөлтийн уялдаа:	ТЭХТБББ 3.2.2.2, ТЭХТБХДХҮХ 3.8.1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий				
	Сурьр түвшин	Тухай бүр идэвхтэй оролцож байна				
	Шалгуур үзүүлэлт	МҮ-ын гадаад бодлого, Эрчим хүчиний тухай хууль, хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцүүлж идэвхитэй оролцох, %				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Тухай бүр идэвхтэй оролцоог хангаж ажилласан байх, 100% Жилийн эцэст: Тухай бүр идэвхтэй оролцоог хангаж ажилласан байх, 100%				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Эрчим хүчиний Хартийн байгууллагатай байнгын холбоотой ажиллаж байна. Эрчим хүчиний хартийн жил бурийн эрсдэлийн үнэлгээ боловсруулах ажилд Монгол Улсын Эрчим хүчиний яамнаас оролцож, асуултыг				

Эрчим хүчний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

	бэглэж хүргүүлсэн. Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр болосон Эрчим хүчний Хартийн гишүүн орнуудын сайд нарын түвшний олон улсын 31 дүгээр хуралд оролцож уг хэлсэн. Монгол Улс бус бүс нутгийн эрчим хүчний интеграцийн бодлогод идэвхтэй байр суурь баримтталж, Азийн хөгжлийн банктай хамтран “Зүүн Хойд Азийн эрчим хүчний хамтын ажиллагааны стратеги” баримт бичиг боловсруулсан. Бус нутгийн эрчим хүчний худалдаа, хөрөнгө оруулалтын асуудалд Эрчим хүчний Хартийн байгууллагатай хамтран ажиллах боломжийн талаар санал илэрхийлж оролцсон.
Зарцуулсан хөрөнгө	-
Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.9.2. НҮБ-ын Ази Номхон далайн нийгэм, эдийн засгийн комисс /UNESCAP/-той эрчим хүчний хамтын ажиллагааг өргөжүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа: ТЭХТБББ 3.2.2.2, ТЭХТБХДХҮХ 3.8.1					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Төрийн захиргааны удирдлагын газар, Р.Батрагчаа				
	Суурь түвшин	Тухай бүр идэвхтэй оролцож байна.				
	Шалгуур үзүүлэлт	МУ-ын гадаад бодлого, Эрчим хүчний тухай хууль, хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцсэн байх, %				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Тухай бүр идэвхтэй оролцоог хангаж ажилласан байх, 100% Жилийн эцэст: Тухай бүр идэвхтэй оролцоог хангаж ажилласан байх, 100%				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийтмийн комисс (АНДЭЗНК)-ын Эрчим хүчний хэлтсээс Эрчим хүчний харилцан холболт асуудлаарх Шинжээчдийн ажлын хэсгийн ээлжит 4 дэх уулзалтад 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, “Power Interconnection and Cooperation Forum 2020” (Эрчим хүчний харилцан холболт, хамтын ажиллагааны форум 2020) арга хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр тус тус зохион байгуулах тухай мэдээллийг хүлээн авч холбогдох төлөөлөлөгчид цахимаар оролцсон. Зүүн хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний харилцан холболт ба хамтын ажиллагааны (NEARPIC) форумын хурээнд АНДЭЗНК-оос Зүүн Хойд Азийн тогтвортой хөгжлийн төлөөх бүсийн эрчим хүчний сүлжээний холболт буюу Бодлого, стратегийн тайланг оролцогчдод танилцуулсан.				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	100%				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%					

Гүйцэтгэлийн зорилт № 1.10. Эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах.

Төлөвлөлтийн уялдаа: Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын зорилт 3.2.2.4.

№ 1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.10.1. Дэлхийн Банктай хамтран Багануур зүүн өмнөд бүс, Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдал бууруулах төслийг хэрэгжүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа: ТЭХТБББ-3.2.2.4, ТЭХТБХДХҮХ-3.10.1.					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Дэлхийн банкны зээл, /Эрчим хүчний тесөл-2/ 42,0 сая ам.долларын зээл, 12,4 сая ам.долларын тусламж				
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Эрчим хүч, түлшний бодлогын хэрэгжилтийн газар, Д.Батзориг				
	Суурь түвшин	Төслийн барилга угсралтын ажил эхэлсэн.				
	Шалгуур үзүүлэлт	Барилга угсралтын ажил үргэлжлэн хийгдэх ажлын явц, %				

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> 1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянана. 2. Гадаадаас төслийн хүрээнд тухай бүр орж ирж буй тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлнэ. 3. ТХН-ын сар, улирлын гүйцэтгэлийг хянан Сангийн яаманд хүргүүлнэ. <b>ТХН-үүдийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох албан бичиг бусад асуудлуудыг зохицуулсан байна, 100%</b> <b>Жилийн эцэст::</b> 1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянана. 2. Гадаадаас төслийн хүрээнд тухай бүр орж ирж буй тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлнэ. 3. ТХН-ын сар, улирлын гүйцэтгэлийг хянан Сангийн яаманд хүргүүлнэ. <b>ТХН-үүдийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох албан бичиг бусад асуудлуудыг зохицуулсан байна, 100%</b>
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Төслийн хүрээнд түгээх сүлжээний алдагдлыг бууруулах, ухаалаг тоолуур суурилуулах, ухаалаг тоолуур, борлуулалтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх ажлууд хийгдэж байна. Борлуулалт, арилжааны программ нэвтрүүлэх ажлын хувьд "ЕСМ" ХХК-тай хийсэн гэрээний дагуу программы нийлүүлж, хэрэгжүүлж, хүлээн авсан. Орхон, Булган, Өвөрхангай, Хархорин, Архангай салбаруудад мэдээллийн бааз хөрвүүлж сургалт хийгдэх ажлын гүйцэтгэл 85% болж, борлуулалтын үйл ажиллагаа шинэ бүтцээр ажиллах боломжтой болсон. Төслийн БУА-удаас Говьсүмбэр аймгийн төвийн шугам сүлжээг шинэчлэх ажил 92,7 хувь; Багануур дүүргийн шугам сүлжээг шинэчлэх ажил 89,0 хувь; Өвөршандын 35/10кВ-ын 10МВА дэд станцын БУА 100 хувь; Булган аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 84,4 хувь; Архангай аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 86,4 хувь; Эрдэнэтийн 35/6кВ-ын 2*10МВА дэд станц 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжих байна. Булган, Архангай, Говьсүмбэр аймгийн төвүүдийн цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлууд тоолуур суурилуулалтаас бусад ажил хийгдэж дууссан. Ухаалаг тоолуурын тендерийн ажил хоцорч байгаагаас шалтгаалан гэрээг сунгах шаардлага гарсан. Өвөрхангай, Хархорин, Дундговь, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдын гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж, хэлэлцээр хийгдэж дууссан. Ховд аймгийн Мянгад суманд барих 110/35/6 КВ-ын 2*25МВА "Мянгад" дэд станцын өргөтгөл шинэчлэлт ажил бүрэн дууссан, гүйцэтгэл 100 хувь, 10 МВ-ын нарны станцын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулаад байна. Орхон, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Дундговь, Дорноговь аймгийн төв, Замын-Үүд сум, Хэнтий аймгийн төв, Бор-Өндөр сумын цахилгаан түгээх сүлжээ шинэчлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зарлаж, 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдөр нээсэн. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрээр G-ICB-A-16-1 "1 фаз ба 3 фазын ухаалаг тоолуур, өгөгдөл цуглуулагч гүйдлийн трансформатор нийлүүлэх" үнэлгээний хорооны шийдвэр гарч 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн в/3632 тоот зөвлөмжийг Дэлхийн банкны "Эрчим хүчиний төсөл-*2" төслийн нэгжид хүргүүлсэн.
	Зарцуулсан хөрөнгө	3,0 сая ам.доллар, 8,4 тэрбум төгрөг
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	1.10.2. Германы Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний өргөтгөл шинэчлэлийн төслүүдийг хэрэгжүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа: ТЭХТБББ-3.2.2.4, ТЭХТББХДХҮХ-3.10.2.					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Xэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Германы Сэргээн Босголт Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээл, 10.4 сая евро				
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий				
	Суурь түвшин	Зээлийн тусгайлсан хэлэлцээр байгуулагдаж УИХ-аар батлагдсан, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдсан.				

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

	Шалгуур үзүүлэлт	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах явц, %
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, 100% Жилийн эцэст: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна, 100%
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Tөслийн зөвлөхөөр ХБНГУ-ын Fitchner компани ажиллаж урьдчилсан шатны судалгааг ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкинд хүргүүлсэн. ЭХЯ, СЯ, ЦДУС ТӨХК болон KfW банкны төслийн үнэлгээний багийн хооронд хэлэлцэн тохиролцсон асуудлуудыг нэгтгэн Харилцан Ойлголцлын Санамж Бичиг (ХОСБ) байгуулсан. Төслийн зөвлөхийн эхний шатны олон улсын нээлттэй тендерийг 2020.03.20-ны өдөр ХБНГУ болон Монгол Улсад нэгэн зэрэг зарласан боловч цар тахлын улмаас тендерийн материалыг хүлээн авах хугацааг тендерт оролцогчдоос ирүүлсэн хүснэгтийн дагуу 3 удаа сунгаж 2020 оны 6 дугаар сард үнэлсэн. Тендерийн үнэлгээний тайланг KfW банкинд хүргүүлж 2020.08.26-ны өдөр "Үл татгалзах мэдэгдэл" хүлээн авсан. Зөвлөхийн хоёр дахь шатны тендерийг 2020.10.31-ний өдөр зарлаж 2020.12.15-ны өдөр тендерийг хүлээн авч KfW банкнаас тендерийг нээж, үнэлгээний матрицийн дагуу техникийн саналын үнэлгээг эхлүүлэх зөвшөөрлийг 2020.12.30-ны өдөр хүлээн авсан ба 2021 онд төлөвлөгөөний дагуу төслийн зөвлөхийн Санхүүгийн саналыг нээж үнэлгээ хийхээр ажиллаж байна.
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	90%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		90%

№ 1 Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.10.3. Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтран Улаанбаатарын дулаан хангамжийн үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэх.					
	Төлөвлөлтийн уялдаа:					
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Европын сэргээн босголт хөгжлийн банкны урт хугацаатай хөнгөлөлттэй зээл, 20.0 сая евро				
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Эрчим хүч, түүшний бодлогын хэрэгжилтийн газар, Д.Батзориг				
	Суурь түвшин	Зээлийн тусгайлсан хэлэлцээр байгуулагдаж УИХ-аар батлагдсан.				
	Шалгуур үзүүлэлт	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах явц, %				
	Хүрэх түвшин	Эхний хагас жилд: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, 100% Жилийн эцэст: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна, 100%				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт хөгжлийн банктай байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд "Улаанбаатарын дулаан хангамж" төслийг санхүүжүүлэхээр хамруулж, зээлийн 10 сая.ам долларын тусгайлсан гэрээнд Засгийн газраас Сангийн сайдад гарын үсэг зурах эрх олгосноор гэрээнд 2020.01.10-ний өдөр гарын үсэг зурсан. 2020 онд Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсан. Төслийн зөвлөхийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг ЕСБХБ-тай зөвшилцсөнөөр 2020.05.15-ны өдөр зарлаж, "Майнтех технологи" ХХК шалгарсан. Банкнаас санхүүгийн тайланд 2020.12.21-ний өдөр Үл татгалзах авсан. Оролцогчдод өгөх тендерийн хариу, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг банканд хянуулахаар илгээсэн, Үл татгалзах авахаар хүлээгдэж байна. Төслийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх барилга угсралтын ажлын төлөвлөгөөг гаргаж банктай зөвшилцсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, ажлыг 2021 оны хоёрдугаар улиралд эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	90%				
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		90%				

Эрчим хүчиний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

№ 1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.10.4. Уур амьсгалын хөрөнгө оруулалтын сангийн бага орлоготой орнуудад сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөрийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчиний төслийг хэрэгжүүлэх.						
	Төлөвлөлтийн уялдаа:	ТЭХТБББ-3.2.2.4, ТЭХТББХДХҮХ-3.10.4.					
Гүйцэтгэлийн шалгур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
	Шаардагдах хөрөнгө	Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, 159.8 тэрбум төгрөг					
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлдзий Сэргээгдэх эрчим хүчиний хэлтэс, И.Лувсанцэрэн					
	Суурь түвшин	Зээлийн тусгайлсан хэлэлцээр байгуулагдаж төслийн нэгж байгуулагдсан, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер зарлагдсан.					
	Шалгур үзүүлэлт	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах явц, %					
	Хүрэх түвшин	<p><b>Эхний хагас жилд:</b> Тэлмэн 5 МВт СЦС, Улиастай 5 МВт-ын НЦС, Есөнбулагт 10 МВт-ын НЦС, Алтай сумын хосолмол систем, Ховдын 10 МВт-ын НЦС, Мянгад 10 МВт-ын НЦС, Ховд аймгийн хөрсний дулааны насос, Мянгадын дэд станцын шинэчлэлтийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг эхлүүлсэн байна, 100%</p> <p><b>Жилийн эцэст:</b> Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж БУА эхлүүлсэн байна,</p> <p>100%</p>					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>МУ-ын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээл, буцалтгүй тусламжийн гэрээнүүд 2019 оны 02 дугаар сард байгуулагдсан. Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөрийн хүрээнд АХБ-ны дэмжлэгтэйгээр нийтдээ 40.5МВт суурилуулсан чадалтай сэргээгдэх эрчим хүчиний тархмал эх үүсвэрийг баруун бүсэд 2019-2023 оны 5 жилийн хугацаанд барьж байгуулах юм.</p> <p>Төслийн хэрэгжилтийн явц оны эцсийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>Увсын Өмнөговь 10 МВт СЦС: Байршлын судалгаа/ Төслийн талбай дээр салхины ЭХ-ийг хэмжих хэмжилт болон нүүдлийн шувууны судалгаа хийгдэж байна. Гүйцэтгэгчийг сонгох тендер зарлах бэлтгэл хангагдсан. Тендерийн YХ байгуулагдсан, тендерийн материалын төсөл бэлэн болсон. Шувууны судалгааны дүгнэлтийг АХБ зөвшөөрснөөр тендер зарлах нөхцөл бүрдэнэ.</li> <li>Ховдын Мянгад 10 МВт-ын НЦС: Гэрээний хэлцлийн шатанд байна.</li> <li>Говь-Алтай, Есөнбулаг 10 МВт НЦС: Тендер шалгаруулалтын шатанд байна. Тендерийг 2 дахь удаагаа зарласан. Тендерийг 2020.12.11-нд хүлээн авсан. 2021 оны 01 дүгээр улиралд эхлүүлнэ.</li> <li>Говь-Алтай, Алтай суманд 300 кВт-ын НЦС: Тендерийн материалыг шинэчилж, хянуулахаар АХБ-нд хүргүүлсэн.</li> <li>Завхан, Улиастай 5 МВт НЦС: Гэрээний хэлцлийн шатанд байна.</li> <li>Завхан, Тэлмэн 5 МВт СЦС: Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах шатанд байна. Салхины эрчим хүчиний хэмжилтийг хийх хэмжилтийн багажны худалдан авалтыг хийсэн, суурилуулалт, хэмжилт хийх ажил цар тахлаас улмаас хойшлоод байна. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг 2020 оны 11 сард эхлүүлсэн, нүүдлийн шувууны судалгаа хийгдэж байна. ТЭЗҮ-ийг салхины эрчим хүчиний хэмжилттэй уялдуулан тодотгоно.</li> <li>Хөвсгөл, Мөрөн 10 МВт-ын НЦС: Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах шатанд байна. ТЭЗҮ-ийг ШУТЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. ТЭЗҮ дэмжигдсэн тул тендерийн бичиг баримтыг бүрдүүлж, 2021 оны 1 дүгээр улиралд тендер зарлана.</li> <li>Төслийн бус нутгийн хүрээнд 5 байрлалд газрын гүний халаалтын систем барих: Ховд аймгийн Жаргалант сумын цэцэрлэгийн барилгын халаалтыг газрын гүний халаалтын системээр шийдвэрлэх төслийн гүйцэтгэгчийг 2020 онд шалгаруулан барилга угсралтын ажил 80 хувьтай байна. Бусад 4 байрлалд судалгаа хийгдэж байна.</li> </ul> <p>Зарцуулсан хөрөнгө</p> <p>Хүрсэн түвшин</p> <p>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</p>					
		330,0 мян ам.доллар, 929,6 сая төгрөг.					
		50%					
		50%					

Эрчим хүчний яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

**Гүйцэтгэлийн зорилт №1.11.** Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах.

**Төлөвлөлтийн уялдаа:** МУ-ын ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан журам, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журам.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.11.1. Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламж, Хөгжлийн банкны санхүүжилтээр <b>Эрчим хүчний эх үүсвэр барих төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хангаж ажиллах.</b>						
Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-2.101, 2.106, МУЭЗНХҮЧ-6.1, ТЭХТБББ- 4.1.1.2, ТЭХТБХДХҮХ-3.21, 3.22, 3.23, 3.24, 3.41						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
	Шаардагдах хөрөнгө	ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлээс 20,0 сая евро, Улсын төсвөөс 10,4 тэрбум төгрөг /Дархан/ БНХАУ-ын 1,0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээс 48,64 сая ам.доллар, Улсын төсвөөс 2,56 сая ам.доллар /Эрдэнэт/ МУХБ-ны 60,0 сая ам.долларын зээл, Улсын төсвөөс 19,48 сая ам.доллар /Чойбалсан/ ЖАЙКА байгууллагын 4,1 тэрбум иенийн хөнгөлөлттэй зээл /MON-P10/ БНСУ-ын Засгийн газрын 148,9 сая ам.долларын зээл, МУЗГ-ын 1,2 сая ам.доллар /10 аймгийн төвийн ДС/					
	Хариуцах нэгж	Бодлого, төлөвлөлтийн газар, Б.Ерэн-Өлзий Хөрөнгө оруулалтын хэлтэс, Б.Огтонцэцгэг					
	Суурь түвшин	УИХ-аар зээлийн хэлэлцээр соёрхон батлагдаж, ажлын гүйцэтгэгч шалгарсан.					
	Шалгуур үзүүлэлт	МУ-ын ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан журам, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журам болон бусад холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийн явц, %					
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> 1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянана. 2. Гадаадаас төслийн хүрээнд тухай бүр орж ирж буй тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлнэ. 3. ТХН-ын сар, улирлын гүйцэтгэлийг хянан Сангийн яаманд хүргүүлнэ. 4. ТХН-үүдийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох албан бичиг бусад асуудлуудыг зохицуулна. 100%					
	<b>Жилийн эцэст:</b>						
		1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянана. 2. Гадаадаас төслийн хүрээнд тухай бүр орж ирж буй тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлнэ. 3. ТХН-ын сар, улирлын гүйцэтгэлийг хянан Сангийн яаманд хүргүүлнэ. 4. ТХН-үүдийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох албан бичиг бусад асуудлуудыг зохицуулна. 100%					
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Төслийд барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянах, гадаадаас орж ирж буй тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлүүлэх, ТХН-ын сар, улирлын гүйцэтгэлийг хянан Сангийн яаманд хүргүүлэх, ТХН-үүдийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох албан бичиг бусад асуудлуудыг зохицуулах ажлуудыг тухай бүр гүйцэтгэсэн. Дээрх төслийдээс ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлээс 20,0 сая евро, Улсын төсвөөс 10,4 тэрбум төгрөгийн санхүүжилттэй /Дархан/ төсөл 100 хувь хэрэгжиж дууссан. 4 төсөл нь график төлөвлөгөөний дагуу хэрэгжилттэй байна.					
	Зарцуулсан хөрөнгө	-					
	Хүрсэн түвшин	100%					
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ	100%						

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин						
Арга хэмжээний нэр, дугаар	1.11.2. Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр Дамжуулах, түгээх шугам сүлжээг шинэчлэн сайжруулах чиглэлээр хэрэгжиж буй төслийд өдөр тутмын хэрэгжилтийг хангаж ажиллах.						
Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-2.105, 2.108, МУЭЗНХҮЧ-6.5, ТЭХТБББ- 4.1.1.5, ТЭХТБХДХҮХ-3.5.1, 3.6.1, 3.10.1-3.10.4,						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
